

БАНК БУС САНХҮҮГИЙН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлагыг тодорхойлох, гадаад валютын арилжааны мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, гадаад валютын арилжаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчилд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2.Санхүүгийн зохицуулах хороо нь Валютын зохицуулалтын тухай хууль болон энэ журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага:

2.1.1. Санхүүгийн зохицуулах хорооноос гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэхэд тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.2 ажлын байрны аюулгүй байдлыг хангасан байх;

2.1.3.үйлчлүүлэгчийн нүүр царай болон арилжаа хийж буй валютын дэвсгэрт ил тод харагдахуйц хүчин чадалтай дуу-дүрс бичлэгийн техник хэрэгсэлтэй байх ба дуу-дүрс бичлэгийг нэг сараас доошгүй хугацаагаар архивлан хадгалдаг хяналтын системтэй байх;

2.1.4.үйл ажиллагааны шаардлага хангасан компьютер, техник хэрэгсэл, валют шалгагч болон мөнгө тоологч машинтай байх;

2.1.5.валютыг худалдан авах, худалдах ханшийг электрон самбар болон цахим талбараар нийтэд ил тод мэдээлэх;

2.2.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбар нь Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т нийцсэн байна.

2.3.Цахим систем ашиглаж гадаад валютын арилжаа эрхлэх тохиолдолд энэ журмын 2.1 болон 2.2-т заасан шаардлага хамаарахгүй болно.

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаанд дараах шаардлагыг тавина:

3.1.1.удирдлага, ажилтан нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны сургалтад хамрагдсан байх ба ажилтан нь хуурамч мөнгөн тэмдэгтийг таньж мэдэх чадвартай байх;

3.1.2.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20-д заасан нэгдсэн системд бүртгэгдсэн байх;

3.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.3.Ажилтан нь мөнгөн тэмдэгтийг тухай бүр хянах бөгөөд гүйлгээнээс хуурамч мөнгөн тэмдэгт илрүүлсэн тохиолдолд гүйлгээг зогсоож, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэн, холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгөх;

3.4.Гадаад валютын арилжаанд санхүүгийн тайланд тусгаагүй эх үүсвэрийг ашиглахгүй байх;

3.5.Гадаад валютын арилжааг пос төхөөрөмж, бэлэн бус гүйлгээгээр хийх тохиолдолд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн харилцах данснаас бусад дансыг ашиглахгүй байх;

3.6.Гадаад валютын үлдэгдлийг зориудаар идэвхгүй төлөвт байлгаж болохгүй бөгөөд валютын ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, хомсдол үүсгэх зорилгоор худал мэдээлэл тараах, валют худалдах, худалдан авах гүйлгээ хийхгүй байх;

3.7.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь хуульд зааснаас бусад үндэслэлээр харилцагчийн мэдээллийг бусдад өгөх, задруулах эсхүл хувийн зорилгоор ашиглахгүй байх;

3.8.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн салбар нэгж нь энэхүү журмын 2.1 болон 2.2-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ НИЙЛҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ

4.1.Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд валютыг худалдан авсан, худалдсан гүйлгээ тус бүрийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасны дагуу нэгдсэн системд илгээнэ.

4.2.Гадаад валютын арилжааны гүйлгээний мэдээллийг цахим хэлбэрээр файл, хавтас үүсгэн компьютерын хатуу дискт 5 жил хадгална.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.